

# НЭГ. ШИЛДЭГ ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, БАГШИЙН ТАСРАЛТГҮЙ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ, ЗААХ БА СУРАЛЦАХУЙН МЭДЛЭГ, ЧАДВАР, ХАНДЛАГЫГ ДЭЭШЛҮҮЛЭХ

## 1.1. Харилцан суралцъя, тасралтгүй хөгжье” сургалт зохион байгуулах

2018 оноос НЭМС-ийн багш нарын дунд болон бусад сургуулийн багш нарыг хамруулсан “Харилцан суралцъя, тасралтгүй хөгжье” нэрийн доор гадаадад болон дотоодод мэргэжил дээшлүүлсэн, сургалтад хамрагдсан хүмүүсийн мэдлэг, мэдээлэл, туршлагыг солилцох уулзалт, семинарыг тогтмол зохион байгуулсаар ирсэн. Энэхүү тогтмол сургалт, семинарын хүрээнд нийт 32 удаагийн танхимын болон цахим сургалтыг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор 1280 хүн хамрагдсан ба 6 удаад нь гадны байгууллагын профессор багш нар ирж харилцан мэдээлэл солилцсон байна.

“Харилцан суралцъя, тасралтгүй хөгжье” сургалтын хүрээнд дараах сэдвүүдээр сургалтыг зохион байлаад байна. Үүнд:

1. 2018.03.27. “Багаар ажиллах”, АШУҮИС, НЭМС, ЭМБТ, Доктор Л.Хоролсүрэн
2. 2018.04.06. “Түүвэрлэлтийн арга”, АШУҮИС, НЭМС, ЭБТ, Магистр Х.Сэр-Од,
3. 2018.05.11. “Мета-Анализ” ДЭМБ-н зөвлөх Yuka Jinnai, MPH, PhD.
4. 2018.05.24. “Шилдэг байгууллагыг бий болгох” Mamoru Yamashita /JICA-н зөвлөх/
5. 2018.05.29. “Газарзүйн мэдээллийн тогтолцоог эрүүл мэндийн тусламж үйлчилгээний практик, судалгаа, зохион байгуулалтын үйл ажиллагаанд хэрэглэх нь”, ОУ-ын сургалт. Pramill N. АНУ-ын Лома Линда Их сургууль
6. 2018.09.27. “Стресс, түүнийг даван туулах арга зам”, АШУҮИС, НЭМС, ЭМНАНУТ, Магистр Т.Жаргалсайхан
7. 2018.10.14. “Үр дүнтэй ажилладаг хүний 7 зарчим”, АШУҮИС, НЭМС, ОЭМТ Магистр Г.Жаргалсайхан
8. 2018.11.20 "Улаанбаатар хотын агаарын бохирдол ба эрүүл мэнд", Rufus D. Edwards, PhD, Профессор. Калифорнийн Их сургууль, НҮБ-ын Хүүхдийн Сан; Speciose Nakizimana, Хүүхдийн сангийн шадар суурин төлөөлөгч
9. 2019.03.06-нд Олон улсын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх арга зүй
10. 2019.03.15-нд Эрдэм шинжилгээний өгүүлэл бичихдээ номзүй эх сурвалжийг шууд холбон бичих overleaf програм ашиглах нь
11. 2019.05.08-нд Зохистой хооллолт
12. 2019.05.23-нд Ном, сурах бичиг, гарын авлагын Зохиогчийн эрхийг хэрхэн авах вэ?
13. 2019.05.29-нд Medical Humanities
14. 2019.05 сард Судалгааны ёс зүй
15. 2019.09 Эрдэм шинжилгээний бүтээл туурвих арга зүй
16. 2019.10-11 Эрх зүй, АТГ сургалтууд
17. 2019. Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Авлигатай тэмцэх газраас “Шударга нийгмийн төлөө хамтдаа”
18. 2020. "Эпигенетикийн судалгаа". АНУ-ын Монтана Их Сургуулийн дэд профессор Чо Юн Хи
19. 2021. Цар тахлын үеийн сэтгэл зүй
20. 2021. Гамшгийн үеийн сэтгэлзүй
21. 2021. Багшийн ёс зүй
22. 2021. Зөв зохистой хооллолт
23. 2021. Цахим дээрэлхэлт

24. 2021. Байгууллагын соёл
25. 2021. Өрхийн санхүү
26. 2021. Хувь хүний санхүү
27. 2021. 2022.04.29. “Судалгааны арга зүй ба бүтээл хэвлүүлэх нь” Багшийн хөгжил, цахим сургалтын газраас зохион байгуулж буй дадлагажигч багш нарт зориулсан сургалтанд “Судалгааны ёсзүй”
28. 2022.05.06. “Хувь хүний манлайлал ба стресс менежмент” Багшийн хөгжил, цахим сургалтын газраас зохион байгуулж буй дадлагажигч багш нарт зориулсан сургалтанд "Ажлын байрны стресс"
29. 2023.02.07. "Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг дэмжих" - Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай ерөнхий ойлголт. ОЭМТ-ийн багш Б.Батчимэг
30. 2023.02.28. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль. ОЭМТ-ийн багш Б.Батчимэг
31. 2023.03.14. Ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийн төрлүүд, зохистой хэрэглээ. ОЭМТ-ийн багш Б.Батчимэг
32. 2023.03.28. "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрсдэлийн үнэлгээ" ОЭМТ-ийн багш Б.Батчимэг

## **1.2. Мэргэжлийн чиглэлээр цахим/зайн сургалтад багш нарыг хамруулах**

Багшийн хөгжил нь хичээл, сургалтын арга зүй, суралцагчдын талаарх мэргэжлийн мэдлэг, чадвар, хандлага төлөвшил, судалгаа хийх, судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлэх, үйлдвэрлэл хэрэглээнд нэвтрүүлэх зэрэг багшлахуйн болон судлан шинжлэх, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд тулгуурлан мэдлэг чадвараа тасралтгүй дээшлүүлж, туршлагаа хуримтлуулах үйл явцыг ахиулахын тулд багш нарыг мэргэжлийн чиглэлээр сургалтад хамруулдаг. АШУҮИС-ийн хэмжээнд “Асуудалд суурилж суралцахуй” (Problem Based Learning /PBL), Анагаах ухааны боловсрол судлал, Калгари их сургуулийн мастер багш бэлтгэх сургалт, сорил боловсруулах, хөтөлбөрийн хөгжил, сургагч багш, дижитал багш/цахим сургалтын арга, заахуйгаас суралцахуйд шилжих нь, харилцан суралцъя тасралтгүй хөгжье, цахим сургалтын технологи, SCORPIA, R программ, T2C, T2T зэрэг сургалтууд танхим болон цахимаар тогтмол зохион байгуулагдаж, багш нар идэвхитэй хамрагдаж байна. Шинээр ажилд орсон дадлагажигч багш нарт зориулан “Менторшип хөтөлбөр, хэрэгжүүлдэг бөгөөд “АУ-ны боловсрол судлал” хичээлд хамруулж, багшийн үнэмлэхийг олгодог.

Залуу багш нарын судалгаа хийх чадавхийг дээшлүүлэх зорилгоор багш нарыг олон улсын болон Засгийн газрын санхүүжилттэй Nature Research Academies сургалт, академик түвшний Англи хэлийг сайжруулах зорилгоор Erasmus+Arrow гэх мэт сургалтад хамруулсан.

2018 оноос хойш Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн 10 гаруй багшийг ХБНГУ, Австрали, Орос, Япон, Солонгос, АНУ, БНХАУ зэрэг улс орнуудын багш судлаачдын зохион байгуулсан сургалтуудад танхим болон цахимаар хамруулсан. Гадаадад мэргэжил дээшлүүлж, сургалтад хамрагдсан 14, олон улсын хурал семинар, чуулганд оролцсон 21 багш байна. Дотоодод зохион байгуулагдсан олон улсын 12 сургалтанд давхардсан тоогоор 132 багш, дотоодын 59 сургалтанд давхардсан тоогоор 509 багш хамрагдаж мэдлэг, мэргэжлээ дээшлүүлсэн. Мөн хамтын ажиллагаатай гадаадын их дээд сургуульд мэргэжил дээшлүүлэх, эрдмийн зэрэг хамгаалах, төгсөлтийн дараах урт богино хугацааны сургалтад хамруулах боломжийг олгож байна.

## Гадаадын богино хугацааны сургалтад хамрагдаж мэргэжил дээшлүүлсэн байдал:

1. Principals of Epidemiology, JHSPH. Э.Эрдэнэчимэг;
2. Faculty development program, Columbia University School of Social work, US
3. Air pollution and Health Training course at WHO Collaborating Center for Air Quality, QUT, Brisbane Australia. Г.Энхжаргал;
4. Waste Management at JICA Yokohama Training Center, Japan. Г.Энхжаргал;
5. Environmental Health at Department of Preventive Medicine of Yonsei University, Korea. Г.Энхжаргал;
6. Statistical Reasoning in Public Health summer course at JHSPH, Baltimore USA. Г.Энхжаргал;
7. Air Quality Monitoring at Shandon Univ, China. Г.Энхжаргал;
8. Johns Hopkins Bloomberg School of Public Health, "Lab internship program for occupational and environmental health", Baltimore, USA. С.Мягмарчулуун;
9. "Maternal and Child Health Issues", Queen's University, Kingston, Canada. М.Мөнхзаяа;
10. "Child and Adolescents Hygiene Issues", Medical University of Irkutsk, Russia. М.Мөнхзаяа;
11. "Epidemiology and Biostatistics", The Johns Hopkins University, Bloomberg School of Public Health, Baltimore, USA. М.Мөнхзаяа;
12. Aging Education - Internships in Aging project, US. Г.Золжаргалан;
13. БНТУ-н "Psikoloji Ag" сэтгэл судлалын байгууллагаас зохион байгуулж буй "Сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэх нь"; "Ress institute" байгууллагаас зохион байгуулсан "NeuroLinguistic Programme 1" сэдэвт сургалт; "DIRIM PSIKOLOJI" сэтгэл судлалын байгууллагаас зохион байгуулсан "Объектив сорилууд"; "Ress institute" байгууллагаас зохион байгуулсан "NLP practitioner" сургалт; "Ress institute" байгууллагаас зохион байгуулсан "NLP master practitioner" сургалт. Т.Жаргалсайхан
14. Канадын Квинсийн Их сургуульд докторын дараах 3 сарын сургалт. Д.Гантуяа;
15. АНУ-ын Миннесота их сургуулийн Нийгмийн эрүүл мэндийн зуны 30 хоногийн сургалт. Д.Оюунбилэг;
16. Канад улсын Queen's-ийн их сургуульд Хүүхэд, өсвөр үеийн болон эхчүүдийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал сэдэвт 3 сарын сургалт. М.Мөнхзаяа;
17. ОХУ-ын Москва хотод ДЭМБ-аас зохион байгуулагдсан "Implementation research methodology" сургалт, захирал Д.Даваалхам, Л.Мөнх-Эрдэнэ;
18. БНХАУ-ын Бээжин хотын талбарын тархвар судлалын сургалтын төвд зохион байгуулагдсан Халдварт бус өвчний менежментийн сургалт. Д.Даваалхам, Л.Мөнх-Эрдэнэ;
19. БНСУ-ын Global Academy for Health Law & Bioethics (GAHL) сургалт. Ц.Нямсүрэн;
20. АНУ-ын Нью Йоркийн их сургууль, Колумбийн Нийгмийн ажлын сургуульд 2 багш;
21. Австрийн Зальцбург хотод "Public Health Law" сэдэвт сургалт. Д.Даваалхам, Ш.Оюу-Эрдэнэ;
22. Erasmus+Arrow төслийн Patent Seminary цахим сургалт. Л.Мөнх-Эрдэнэ;
23. АНУ-ын Лома Линда их сургууль. Тамхинаас гаргах эмчилгээ, зан үйлийг өөрчлөх зөвлөгөөний аргазүй. Д.Мөнх-Учрал;
24. "Internationally Accredited Diploma in Sport Nutrition" online course. Н.Туул;
25. "The Gut & Microbiome program" Well college global Australia. Н.Туул;
26. Clinical & Forensic Toxicology Studies (Department of Forensic Medicine & Science, Cukurova University, Republic of Turkey). Б.Лувсанлхүндэв;
27. "Culinary Health Education Fundamentals (CHEF) Coaching—The Basics" Harvard Medical School. цахим сургалт. Ү.Эрдэнэзул;
28. "Proficiency certificate in Nutrition VRE 504" Warnborough College. Д.Ням-Осор
29. "Nutrition Science" Stanford Center for Health Education. Л.Хулан;

30. "Clinical counselling" Australia, Sir Charles Gardner hospital, "Mental health" Australia, Curtin University. Ч.Азаяа;  
 31. NIH U2R fellowship program, Duke University. Б.Буянтүшиг, Г.Одмаа, А.Энхдөлгөөн;

### 1.3. Гадаад зочин багшийн тоог нэмэгдүүлэх

Манай сургууль жил бүр Director at Institute of Global Health-MSUCOM; College of Public Health, National Taiwan University; Graduate School of Public Health, Seoul National University; Simon Fraser University, Faculty of Health Sciences; Эрхүүгийн АУИС; Murdock University, Australia, University of Tsukuba School of Medicine and Medical Sciences гэсэн нийт 7 байгууллагын профессор багш нарыг зочин багшаар урьж ажиллуулж байна (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Зочин багш нар

| № | Чиглэл                            | Зочин багшийн нэр   | Зочин багшийн цол, зэрэг | Зочин багшийн харъяалагддаг сургууль                            |
|---|-----------------------------------|---------------------|--------------------------|---|
| 1 | Эрүүл мэндийн бодлого             | Sung Soo Chung      | Ass.professor. Ph.D      | Director at Institute of Global Health-MSUCOM                   |
| 2 | Орчны эрүүл мэнд                  | Chang-Chuan Chan    | Professor, Sc.D          | College of Public Health, National Taiwan University            |
|   |                                   | Jong Ho Lee         | Professor, Sc.D          | Graduate School of Public Health, Seoul National University     |
|   |                                   | Allen Rain          | Professor                | Simon Fraser University, Faculty of Health Sciences             |
|   |                                   | Tamara S. Krupskaya |                          | Эрхүүгийн АУИС  |
| 3 | Эпидемиологи Биостатистик         | Kim Mullholand      | Professor,PhD            | Murdock University, Australia                                   |
| 4 | Урьдчилан сэргийлэх анагаах ухаан | Yumi Hashizume      | Professor                | University of Tsukuba · School of Medicine and Medical Sciences |

- АНУ-ын Олон улсын байгаль, орчин, хөдөлмөрийн эрүүл мэндийг дэмжих салбар дундын эрдэм шинжилгээ, сургалтын төв (GEOHealth) байгуулах төсөлд “Монгол дахь орчин ба хөдөлмөрийн эрүүл мэндийн төв”-ийг байгуулах U01 ба U2R хамтарсан төсөлд Техасын Их Сургуулийн профессор Gregory Gray, Дюкийн Их Сургуулийн профессор Jim Zhang нартай цахимаар хамтран ажиллаж байна.
- Австралийн Мурдокийн Их Сургуулийн Хүүхдийн Институтийн профессор Ким Муллхоландтай хамтран төсөл хэрэгжүүлж байна.
- АНУ-ын Фулбрайт мэргэжилтний хөтөлбөрт ЭМНА-ны бакалаврын болон магистрын хөтөлбөрийн уялдааг хангах, багш нар болон төгсөгчдийн чадавхийг бэхжүүлэх зорилт бүхий төслийг илгээж, амжилттай шалгарсан.
- Зүүн Финландын их сургуультай хамтарсан зуны сургалтыг 2022 оны 6 сарын 15 өдөр зохион байгуулсан.

#### **1.4. Гадаад болон дотоодод багш, оюутан солилцооны хөтөлбөр хэрэгжүүлэх**

Дорнод Сибирийн технологи удирдлагын их сургууль нь 2015 оноос хойш НЭМС-ийн Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхимтэй эрдэм шинжилгээ, сургалт, оюутан солилцооны хүрээнд хамтран ажиллаж байна. 2018 оноос хойш багш, оюутан солилцооны төсөл хэрэгжүүлж Ирасмус Мундус сан, Финляндын Тамперегийн их сургуультай хамтран ажилласан.

1. Их дээд сургуулийн мэргэжлийн бус ангийн оюутнуудад заагдаж буй “Монголын түүх соёл, ёс заншил” хичээлийн хүрээнд оюутан солилцох сургалтыг 2018.03-2018.04.10 ны өдрүүдэд зохион байгуулж уг үйл ажиллагаанд АШУҮИС, МУБИС, ХСИС-ууд оролцсон. Энэхүү үйл ажиллагаанд нийт 5 удаагийн сургалтаар АШУҮИС-ийн 50 оюутан, МУБИС, ХСИС-ийн хичээлд, ХСИС-ийн 20, МУБИС-ийн 20 оюутан тус тус хамрагдсан. Сургуулиуд хүлээж авч буй оюутнууддаа сургуулиа танилцуулах, музей үзүүлэх, дараагийн тэмцээн уралдаанд оюутнуудыг урьж оролцуулах зэрэг арга хэмжээг зохион байгуулсан.
2. 2018.02-оос 05 сарын хугацаанд Япон-Польшийн хамтарсан мэдээлэл технологийн академийн оюутан Agnieszka Czajka НЭМС дээр ирж суралцсан.
3. 2019 онд оюутан солилцоог эхлүүлж, гадаадын 22, Монгол 19 оюутанг хамруулж, ОХУ-д оюутны дадлагыг зохион байгуулсан.
4. Сөүлийн үндэсний их сургуультай хамтран оюутан солилцооны хөтөлбөрийг 2019 оны 1-2 сард зохион байгуулж, Солонгос -15, Монгол 15 оюутанг хамруулсан.
5. ОХУ-ын Өвөр байгалийн улсын их сургуультай хамтран ӨБУИС-ийн Сурган, сэтгэл судлал, НЭМС-ийн Эрүүл мэндийн нийгмийн ажилтны ангийн оюутнуудыг солилцооны хөтөлбөрөөр танилцах дадлага хийлгэх ажлыг 5 болон 6-р сард зохион байгуулсан. ӨБУИС-7, Монгол-4 оюутанг хамруулсан.
6. Финляндын Тампере их сургуультай оюутан, багш солилцооны хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Энэ төслийн хүрээнд 2 улсаас 1:1 докторант, 1:1 багш харилцан суралцахаар болсон.
7. Зүүн Финляндын Куопогийн их сургуультай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд 2021 оны 09-10 сард сонгон шалгаруулалт явуулж бакалавр-1, магистр-1, доктор-1 оюутан тус тус оюутан солилцооны хөтөлбөрт хамруулсан. 2022 оны 3 сард ЭМЭЗ-ийн 1 оюутан (бакалавр), магистр 1, докторын сургалтанд 1 тус бүр 3 сарын хугацаатай явахаар
8. 2022.06.15-нд НЭМС-ийн Зүүн Финляндын Их Сургуультай хамтарсан багш, оюутан солилцооны хүрээнд тус сургуулийн НЭМ-ийн магистрын хөтөлбөрийн захирал Профессор Жюси Кауханен, Нийтийн эрүүл мэндийн бодлого болон эдийн засгийн тэнхимийн ахлах багш, дэд профессор П.Жавхланбаяр нар “Эрүүл мэндийн тэгш бус байдлын нийгэм-эдийн засгийн болон сэтгэл зүйн асуудлууд”, “Эрүүл мэндийн систем, тогтвортой хөгжлийн зорилго ба эрүүл мэндийн тэгш бус байдал” сэдэвт сургалтад.